

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/136/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд хот 2019 он	Тэргүүлэх аудитор:	Ч.Ариунаа
	Утас: 70522734	Цахим хаяг: Dornogovi@audit.gov.mn
	Аудитын менежер:	Ц.Лүндэгмаа
	Утас: 70523020	Цахим хаяг:
	Аудитор:	О.Нарангарав
	Утас: 70523020	Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

Агуулга

<u>1</u>	<u>Аудитын гэрчилгээ</u>	3
<u>2</u>	<u>Аудитын тайлан</u>	5
2.1	<u>Оршил</u>	5
2.2	<u>Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага</u>	5
2.3	<u>Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт</u>	6
2.4	<u>Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин</u>	6
2.5	<u>Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ</u>	7
2.6	<u>Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал</u>	8
2.7	<u>Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар</u>	8
2.8	<u>Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн</u>	8
2.8.1	<u>Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал</u>	9
2.9	<u>Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал</u>	9
2.10	<u>Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга</u>	10
2.11	<u>Шилэн дансны мэдээлэл</u>	11
2.12	<u>Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга</u>	11
2.13	<u>Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл</u>	11
<u>3</u>	<u>Аудит хийсэн санхүүгийн тайлан</u>	12
4.1	<u>Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан</u>	12
4.2	<u>Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан</u>	13
4.3	<u>Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан</u>	14
4.4	<u>Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</u>	16
4.5	<u>Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан</u>	17

1 Аудитын гэрчилгээ


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
Орхи нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД
ДАХЬ ГААЛИЙН ГАЗРЫН ДАРГА
Ц.ОТГОНЖАРГАЛ ТАНАА

2019.02.01 № 1-6/40
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газар нь 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг байгууллагын дарга Ц.Отгонжаргал-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газар 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.01.23-наас 2019.01.26-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.01.30-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-ын О.Нарангарав хариуцаж хэрэгжүүлэв.

Сайншанд дахь Гаалийн газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т 2019.01.18-ны өдрийн 13 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газар талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Сайншанд дахь Гаалийн газар нь “үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

2018 онд байгуулсан үр дүнгийн гэрээгээр Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газар үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Гаалийн байгууллага хоорондын хамтын үйл ажиллагааг идэвхжүүлэх
- Хууль бус худалдаатай тэмцэх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шаардлагатай дүрэм журмыг боловсруулах, хэрэгжилтийг хангах

- Гаалийн байгууллагын хүний нөөцийн цогц бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх
- Гаалийн лабораторийг бэхжүүлэх, үйл ажиллагааг өргөтгөх
- Гаалийн зөрчлийн мэдээллийн нэгдсэн санг боловсронгуй болгох, гаалийн зөрчлийн талаар мэдээлэл солилцох, тандалт судалгаа явуулах

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газар үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газар удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Засгийн газрын тогтоол шийдвэрүүд
- Сангийн сайдын төсвийн үйл ажиллагаатай холбоотой тушаалууд
- Гаалийн ерөнхий газрын холбогдох хууль тогтоомж

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байхгүй

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газар санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг

үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Сайншанд дахь Гаалийн газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Юникус” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газар дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газар бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 13 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардал-ын 1 хувиар сонгов.

Нийт зардал-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тус байгууллагын хувьд зардлын гүйцэтгэлийг чухалчилж үзсэнтэй холбоотой юм.

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газар 2018 оны *Нийт зардал* 723.8 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 7,2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 1 хувиар тооцсонтой холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 11 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 8 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	0	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	163.7	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	1	163.7	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Зардлын данстай холбоотой асуудал

Нийт бодогдсон цалин болон Нийгмийн даатгалын тайлангийн цалингийн дүн 115.7 мянган төгрөгөөр зөрүүтэй, энэ нь албан хаагчдын цалингаас НДШ зардлыг дутуу тооцон авсантай холбоотой байлаа. Уг дутуу суутгалыг авлагаар бүртгээгүй байна.

Энэ нь Иж бүрэн байх, Тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал, Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тус тус зөрчсөн байна..

Шийдвэрлэсэн:

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулан бүртгэсэн.

2.8.1.2 Орлогын данстай холбоотой асуудал

Нийгмийн даатгалын сангаас шилжиж орж ирсэн жирэмсэн амаржсаны 1.5 сая төгрөг, оршуулгын тэтгэмжийн 1.0 сая төгрөг буюу нийт 2.5 сая төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд тусгагдаагүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалын “Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журам”-ын 3.6 дах заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулан бүртгэсэн.

2.8.1.3 Зардлын данстай холбоотой асуудал

Анхан шатны бүрдэл дутуу, шаардлага хангахгүй томилолтын хуудсаар 1 хүнд 163.7 мянган төгрөгийн албан томилолтыг олгосон байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5 дахь заалт, Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаал тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоох

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газрын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газар чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 15 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 648.5 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 3.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 636.8 сая төгрөг буюу 98.2 хувьтай, 11.7 сая төгрөгийн хэмнэлттэй гарсан нь бараа ажил үйлчилгээний зарим зардал зарцуулагдаагүй үлдсэн нь шалтгаалжээ.

Түрээсийн орлогыг 3.4 сая төгрөгөөр давуулан биелүүлж, цалин, НДШ-ийн зардал 11.1 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Сайншанд дахь Гаалийн газар нь 2018 онд улсын төсвөөс 648.5 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 4.9 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 6.0 сая төгрөг, НДС-ийн тэтгэмжийн орлого 2.5 сая төгрөг буюу нийт 661.9 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

Албан хаагчдын цалин, НДШ-ийн зардал 527.1 сая төгрөг нь нийт зардлын 79.6 хувь, бараа үйлчилгээний урсгал зардал 119.6 сая төгрөг нь нийт зардлын 18.1 хувь, Төвлөрүүлэх шилжүүлгийн зардал 15.2 сая төгрөг нь нийт зардлын 2.3 хувийг тус тус эзэлж байна. Тайлант оны эцэст зарцуулагдаагүй төсвийн үлдэгдэл 15.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Сайншанд дахь Гаалийн газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газар 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>43,609,648.80</u>	<u>45,962,894.86</u>
33	АВЛАГА	4,811.04	115,756.43
335	Бусад авлага	4,811.04	115,756.43
3351	Байгууллагаас авах авлага	4,811.04	
3352	Хувь хүмүүсээс авах авлага		115,756.43
35	БАРАА МАТЕРИАЛ	43,604,837.76	45,847,138.43
35300	Бэлэн бүтээгдэхүүн	22,487,134.70	22,605,153.39
354	Хангамжийн материал	21,117,703.06	23,241,985.04
35410	Бичиг хэргийн материал	2,283,859.00	4,597,580.00
35420	Аж ахуйн материал	13,833,057.06	15,201,392.14
35430	Сэлбэг хэрэгсэл	1,480,000.00	1,300,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,778,000.00	828,837.90
35460	Хүнсний материал	122,887.00	378,275.00
35470	Бусад хангамжийн материал	619,900.00	935,900.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>984,316,676.47</u>	<u>1,256,381,234.02</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	984,316,676.47	1,256,381,234.02
391	Газар		369,616,000.00
392	Биет хөрөнгө	984,140,676.47	886,655,234.02
39201	Барилга, байгууламж, орон сууц	883,615,644.00	840,448,018.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	149,229,762.54	165,546,778.86
39203	Авто-тээврийн хэрэгсэл	98,736,017.00	98,736,017.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	82,248,787.69	91,802,012.84
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	344,722,428.90	344,722,428.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	126,732,122.78	149,475,612.42
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55,734,695.40	55,734,695.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	40,457,435.82	46,161,521.76
393	Биет бус хөрөнгө	176,000.00	110,000.00
39301	Програм хангамж	980,000.00	980,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	804,000.00	870,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,027,926,325.27</u>	<u>1,302,344,128.88</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,027,926,325.27</u>	<u>1,302,344,128.88</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,027,926,325.27	1,302,344,128.88
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	924,014,053.34	1,351,674,038.04
51101	Өмч: - төрийн	924,014,053.34	1,351,674,038.04
512	Хуримтлагдсан үр дүн	(332,681,954.07)	(384,712,525.06)
51210	Өмнөх үеийн үр дүн	(460,934,610.18)	(332,681,954.07)
51220	Тайлант үеийн үр дүн	128,252,656.11	(52,030,570.99)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	436,594,226.00	335,382,615.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,027,926,325.27</u>	<u>1,302,344,128.88</u>

3.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын зүйл	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	803,893,910.96	671,770,340.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	168,777,110.96	17,392,940.00
120	Нийтлэг татварын бус орлого	168,777,110.96	17,392,940.00
120005	Түрээсийн орлого	-	3,402,000.00
120009	Бусад орлого	168,777,110.96	13,990,940.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	635,116,800.00	654,377,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	635,116,800.00	648,491,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	630,116,800.00	648,491,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	5,886,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,886,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	675,037,737.71	723,800,910.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	675,037,737.71	723,800,910.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	644,268,339.35	708,739,146.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	452,072,567.03	470,608,368.19
210101	Үндсэн цалин	443,402,567.03	462,028,368.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,670,000.00	8,580,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,725,040.06	56,447,466.36
210201	Тэтгэврийн даатгал	50,725,040.06	56,447,466.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,139,325.00	56,668,500.10
210301	Гэрэл, цахилгаан	13,086,736.00	17,454,500.00
210302	Түлш, халаалт	35,058,389.00	35,219,800.10
210303	Цэвэр, бохир ус	3,994,200.00	3,994,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,569,506.29	14,818,394.31
210401	Бичиг хэрэг	3,782,733.85	4,259,480.00
210402	Тээвэр, шатахуун	6,240,600.00	7,741,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	821,880.20	809,139.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	311,367.00	172,255.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	172,901.46	1,836,520.31
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,467,659.00	36,522,820.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	551,500.00	636,820.00
210604	Урсгал засвар	12,548,359.00	35,886,000.00
2107	Томилолт, зочны зардал	621,960.00	1,654,000.00
210702	Дотоод албан томилолт	621,960.00	1,654,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,232,690.00	17,335,780.96
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,916,800.00	2,261,711.04
210803	Даатгалын үйлчилгээ	1,920,200.00	1,793,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	201,910.00	200,718.00
210807	Газрын төлбөр	14,008.00	28,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	179,772.00	13,051,651.92
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,439,591.97	54,683,817.05
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	180,000.00	300,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,852,174.97	54,383,817.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,769,398.36	15,061,764.02
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,369,398.36	15,061,764.02
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,369,398.36	15,061,764.02
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	128,856,173.25	(52,030,570.99)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	128,252,656.11	(52,030,570.99)

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>635,116,800.00</u>	<u>661,858,929.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	4,860,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	4,860,000.00
120005	Түрээсийн орлого	-	4,860,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	635,116,800.00	656,998,929.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	635,116,800.00	648,491,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	630,116,800.00	648,491,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	6,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		6,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	2,507,529.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		2,507,529.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>635,116,800.00</u>	<u>661,858,929.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	635,116,800.00	661,858,929.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	604,347,401.64	642,717,635.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	451,632,946.94	470,724,124.62
210101	Үндсэн цалин	264,123,446.94	314,782,662.61
210102	Нэмэгдэл	122,564,900.00	92,605,425.01
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,061,500.00	10,051,000.00
210104	Урамшуулал	40,000,000.00	53,285,037.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,514,000.00	56,447,466.36
210201	Тэтгэврийн даатгал	51,514,000.00	41,031,099.99
210202	Тэтгэмжийн даатгал	-	3,630,566.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	2,773,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	693,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	8,319,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,572,236.00	54,719,338.00
210301	Гэрэл, цахилгаан	13,086,736.00	17,454,500.00
210302	Түлш, халаалт	30,491,300.00	33,270,638.00
210303	Цэвэр, бохир ус	3,994,200.00	3,994,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,278,159.70	10,010,121.00
210401	Бичиг хэрэг	1,727,279.50	900,000.00
210402	Тээвэр, шатахуун	6,240,600.00	7,740,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	821,880.20	859,539.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,000.00	167,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	344,400.00	342,782.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,025,954.00	37,933,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,410,500.00	1,426,400.00

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	617,800.00	620,700.00
210604	Урсгал засвар	30,997,654.00	35,886,000.00
2107	Томилолт, зочны зардал	621,960.00	1,654,000.00
210702	Дотоод албан томилолт	621,960.00	1,654,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,044,745.00	10,929,486.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,916,800.00	2,916,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,920,200.00	1,793,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	201,910.00	136,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	64,718.00
210807	Газрын төлбөр	14,008.00	28,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,991,827.00	5,990,168.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,657,400.00	300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	180,000.00	300,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,769,398.36	19,141,293.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,400,000.00	2,507,529.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		2,507,529.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,369,398.36	15,175,764.02
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	-	114,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,369,398.36	15,061,764.02
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,458,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,458,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=====	=====
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	924,014,053.34	436,594,226.00	-332,681,954.07	1,027,926,325.27
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	427,659,984.70			427,659,984.70
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	427,659,984.70	0.00	0.00	427,659,984.70
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-101,211,610.10		-101,211,610.10
D08	Тайлант үеийн үр дүн			-52,030,570.99	-52,030,570.99
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,351,674,038.04	335,382,615.90	-384,712,525.06	1,302,344,128.88

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	648,491,400.00	636,831,635.98	11,659,764.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	648,491,400.00	636,831,635.98	11,659,764.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	648,491,400.00	636,831,635.98	11,659,764.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	480,588,400.00	470,724,124.62	9,864,275.38
210101	Үндсэн цалин	315,926,900.00	314,782,662.61	1,144,237.39
210102	Нэмэгдэл	97,000,000.00	92,605,425.01	4,394,574.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,061,500.00	10,051,000.00	2,010,500.00
210104	Урамшуулал	55,600,000.00	53,285,037.00	2,314,963.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,670,700.00	56,447,466.36	1,223,233.64
210201	Тэтгэврийн даатгал	41,031,100.00	41,031,099.99	0.01
210202	Тэтгэмжийн даатгал	4,159,900.00	3,630,566.37	529,333.63
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,327,900.00	2,773,000.00	554,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	832,000.00	693,000.00	139,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,319,800.00	8,319,800.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,940,000.00	54,719,338.00	220,662.00
210301	Гэрэл, цахилгаан	17,454,500.00	17,454,500.00	-
210302	Түлш, халаалт	33,491,300.00	33,270,638.00	220,662.00
210303	Цэвэр, бохир ус	3,994,200.00	3,994,200.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	10,150,100.00	10,010,121.00	139,979.00
210401	Бичиг хэрэг	900,000.00	900,000.00	-
210402	Тээвэр, шатахуун	7,740,600.00	7,740,600.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	982,500.00	859,539.00	122,961.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	344,400.00	167,200.00	177,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	342,782.00	(342,782.00)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,047,100.00	32,047,100.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,426,400.00	1,426,400.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	620,700.00	620,700.00	-
210604	Урсгал засвар	30,000,000.00	30,000,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	1,654,000.00	1,654,000.00	-
210702	Дотоод албан томилолт	1,654,000.00	1,654,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,141,100.00	10,929,486.00	211,614.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,916,900.00	2,916,900.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,920,200.00	1,793,700.00	126,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	136,000.00	136,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	140,000.00	64,718.00	75,282.00

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210807	Газрын төлбөр	28,000.00	28,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	6,000,000.00	5,990,168.00	9,832.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	300,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	300,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	648,491,400.00	651,893,400.00	(3,402,000.00)
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	648,491,400.00	648,491,400.00	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	648,491,400.00	648,491,400.00	-
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	3,402,000.00	(3,402,000.00)
120005	Төрийн өмч түрээслүүлсний орлого	-	3,402,000.00	(3,402,000.00)